

Монгол шүлэг судлалын өнгөрсөн хийгээд ирээдүй

Г. Галбаяр*

Хүн төрөлхтний бүтээсэн оюуны соёлын гайхамшигт зүйлүүдийн нэг нь урлаг, уран зохиол билээ. Хүн сэтгэхүйтэй сэтгэлийн амьтны хувьд мэдэрч ухаарсан ямар нэг зүйлээ үндэснийхээ хэлний хамгийн төгөлдөр бүтэц, зүй тогтлын хүрээнд дүрслэн илэрхийлдэг. Үүнийг хүн төрөлхтөн шүлэг хэмээн нэрлэж заншжээ. Шүлэг найраг туурвигч үндэстнийхээ зөн мэдрэмж, сэтгэлийн илэрхийлэл, аж амьдралын дүр зураг болох тул тухайн үндэстний сэтгэлгээний ерөнхий хэв загварыг хадгалдаг гэж ойлгогдоно. Аливаа үндэстэн шүлэг найрагаа гадаад дотоод олон талаас нь учир шалтгаант зүйлсийнх нь хүрээ хамааралд нарийвчлан судлан шинжилж өөрсдийн өнгөрсөн түүхэн ул мөр, ирээдүйн хөгжил дэвшлийн зам мөрөө томьёолох нь жам. Тиймд шүлэг яруу найргийг хүн төрөлхтөн ихэд хүндэтгэн эрхэмлэн дээдэлж өөрсдийн өнгөрсөн амьдралын нууц өв сан, ирээдүйн амьдралын зөнч түүчээ хэмээн ухаардаг байна.

Шүлэг найргийг судлан шинжилж, түүнд хадгалагдсан аж амьдралынхаа өнгөрсөн хийгээд ирээдүйн мөн чанар, учир холбогдлыг ухаарахаас гадна тэрхүү шүлэг найраг ямар аргаар, ямар зүй тогтлоор бүтдэг онцлогийг судлан шинжлэх зайлшгүй шаардлагатай асуудал. Учир нь аливаа үндэстний шүлэг найргийн бүтэц тогтолцоо тухайн үндэстнийхээ сэтгэлгээний ерөнхий хэв загварын төлөөлөл болдогтой холбоотой. Энэ утгаараа шүлэг туурвигч үндэстнийхээ хэлний олон талын онцлог шинжүүдийг цогцоор нь хадгалж байдаг өвөрмөц урлаг билээ.

Монгол шүлэг түүхэн урт удаан хугацаанд маш нарийн тогтолцоонд орж, гадна дотны олон зүйлийн учир шалтгаанд хөгжин хувьсаж ирсэний хувьдаа нарийвчлан судлууштай олон асуудлыг бий болгосон юм. Монгол шүлгийг судлан шинжлэх ажил нэн эртний түүхтэй ч шинжлэх ухааны үндэслэлтэй судалсан нь XIX зуунаас эхэлж, XX зуунд тодорхой амжилтанд хүрчээ.

Бид энэ удаа доорх хэдэн зүйлийн зорилго тавьсан болно. Нэгд, монгол шүлэг судлалаар хийгдсэн судалгаа шинжилгээг нэгтгэн дүгнэх, хоёрт, монгол шүлэг судлалаар шийдвэрлэгдсэн гол асуудлуудыг тодорхой болгох, гуравт, цаашид монгол шүлэг судлалын хүрээнд судлан шинжлүүштэй асуудлуудыг гаргаж тавихыг зорьж байна.

Нэг. Монгол шүлгийг судлан шинжлэх ажил нэн эрт үеэс эхэлж, өдгөө шинжлэх ухааны тогтолцоотой салбар ухаан болж хөгжсөн байна. Монгол шүлгийг судлан шинжлэхдээ үе үеийн судлаачид шүлгийн тухай ерөнхий онол ухагдахууны үүднээс авч үзсэн төдийгүй оюуны соёлын хувьд эртнээс холбоо харилцаатай явж ирсэн улс орнуудын шүлэг найрагтай холбогдуудан судлан шинжилсээр ирсэн онцлог харагдаж байна. Монгол шүлгийн тогтолцооны асуудал судалгаанд хэдий үеэс татагдан орсон, ямар шийдэлд хүрсэн, цаашид аль талын ямар судалгаа дутагдаж байгаа зэргийг нэн тэргүүнд авч үзэх нь чухал юм. Ингэж үзвэл нэлээд сонин зүйл ажиглагдаж байна. Учир нь монголчууд сүүлийн хэдэн зуун жил монгол шүлгийн судлал, хөгжил дэвшлийн тухай олон арван сүмбэм туурвисан ч ихэвчлэн Энэтхэгийн дуун ухаантан, зохист аялгуун онолч Дандиний “Гавьяадарша” буюу “Зохист аялгуун онол”-ын үлгэрээр шүлэг зохиол хэрхэн бичих хийгээд “Зохист аялгуун онол”-ын тухай тайлбар сэлт үйлдсээр ирсэн болохоос биш яг монгол шүлгийн дотоод мөн чанарын онцлог, тогтолцооны асуудлыг нарийвчлан авч үзсэнгүй. Тийм ч учраас хожим Оросын монголч эрдэмтэн А. М. Позднеев монгол аман зохиолын тухай өгүүлсэн “Ардын аман зохиолын жишээ” хэмээх бүтээлдээ “монгол шүлгийн тухай түүнийг сонсоход эвтэй бөгөөд ойлгоход хялбар үгээр бадаг бадгийн мөрийг аль болохуйц тэгшээр орчуулах ёстой гэж “Мэргэд гарахын орон” гэдэг нэр томъёоны толь бичигт хэдхэн мөр үг байдгаас өөр монголчуудын бичсэн шинжилсэн зүйл байхгүй”¹ гэж цохон тэмдэглэсэн байна.

Монгол шүлгийн тогтолцоог дагнан судлах ажил XIX зууны үеэс эхэлж, өнгөрсөн зуунд нэлээд эрчимтэй өрнөсөн ч монгол шүлгийг хэн хэн гэдэг судлаачид аль өнцгөөс нь хэрхэн судалж, ямар шийдэлд хүрснийг нэгтгэн багцалж үзсэн нь үгүй байна. Монгол шүлгийн тогтолцоог судалсан эрдэмтэн, судлаачдын судалгааг нэгтгэж үзвэл доорх шийдэлд хүрсэн нь харагдаж байна. Үүнд: нэгдүгээрт, хамгийн анх оросын нэрт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов “Монгол бичгийн хэл ба халх аялгууг харьцуулсан хэлний зүй” /1929/ гэдэг бүтээлдээ халх ардын дуун дээр ажиглалт хийж “Халхын уянгын дуу нь ихэвчлэн өргөлтийг

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш

¹ Позднеев А. М. Образцы народной литературы монгольских племен. Вып I. Спб., 1880. срт-232

тэгштгэх зарчмаар зохиогдсон тул өргөлтөт шүлэг болно”² гэж таамаглал дэвшүүлснийг оросын монголч эрдэмтэн Н. Н. Поппе 1936 онд хэвлүүлсэн “Халх-монголын баатарлагын туульс” бүтээлдээ дэлгэрүүлэн монгол шүлгийн үндсэн хэмжээ нь Б. Я. Владимирцовын авч үзсэнчлэн 3-7 орчим өргөлтөт үеэс бүрдэж байна гэж тэмдэглэжээ. Түүний дараа буриадын эрдэмтэн А. Хамгашалов 1940 онд хэвлүүлсэн “Буриад-монгол шүлэг зохиолын шинжилгээний туршлага” бүтээлдээ “Буриадын шүлэгт өргөлтөт шүлгийн тогтолцоо нь зөвхөн өнөөдөр ноёлох төдий байртай биш чухамдаа өнөөдрийг хүрч иртэл аман ба бичгийн зохиолд бараг ганцаараа ноёрхож байгаа юм. Буриад-монголын шүлгийн зохион байгуулалтыг үзэхэд шүлгийн мөр дэх үгийн тоог тэгштгэх аргыг баримталсан нь үгийн өргөлт ямагт нэгдүгээр үедээ байдгаас шалтгаалсан байна”³ хэмээн дүгнэжээ. Тэдний энэ саналыг манай эрдэмтэдээс Ц. Дамдинсүрэн, М. Гаадамба, Н. Жамбалсүрэн, Д. Жамба, Ч. Чимид зэрэг хүмүүс дэмжиж, өөр өөрийн судалгаа, түүнээс гарсан дүгнэлтээрээ гүнзгийрүүлэн баглахыг зорьжээ. Тухайлбал Ц. Дамдинсүрэн “Олег цэцний орчуулгын тайлбар” хэмээх 1937 онд бичсэн өгүүлэлдээ “Монгол үгийн тогтвортой бат эгшиг нь үгийн эхний өргөлтөт эгшиг мөн. Энэ эгшиг бол шүлгийн гол багана тулгуур мэт тул “Олег цэцний дуулал”-ыг орчуулахдаа энэ өргөлтөт эгшигийг гол болгон баримталж, энэ өргөлтөт эгшигийг тэгштгэн хэрэглэсэн билээ”⁴ гэж тэмдэглэсэн нь монгол шүлгийн тогтолцооны талаар өөрийн саналыг хэлсэн төдийгүй орос хэлнээс шүлэг орчуулахдаа өргөлтөт эгшигийг тэгштгэх журмыг баримтлах нь зохихыг тэмдэглэсэн хэрэг бололтой. Мөн М. Гаадамба “Монгол үгэнд үг нэг бүр нэг өргөлттэй учир мөр дэх өргөлтийн тоо тэнцүү байна гэдэг бол мөр бүрийн үгийн тоо тэнцүү байна гэсэн санаа мөн. Шүлгийн мөр бүрд орсон өргөлтөт үеийн тоо тэнцүү байхад үндэслэдгээс монгол шүлэг бол үндсэндээ тоник буюу өргөлтийн шүлэг болно”⁵ хэмээн үзсэн байхад Н. Жамбалсүрэн “Шүлгийн мөрт үгийн тоо тэгш байх нь монгол шүлгийн үндсэн хэмжээ байдаг гэж А. Хамгашалов зүйтэй дүгнэжээ. Шүлгийн мөр 2-10 хүртэл /өргөлт/ үгтэй. Бадгийн доторх мөрүүд адил байвал үлгэр үзэмж байгууламжийн хувьд жигд сайн болдог байна. Гол өргөлтийн тоог ямар нэг хэмжээгээр тэгш байлгах нь монгол шүлгийн үндсэн хэмжээ болсоор ирсэн, хойшид ч сайн шүлгийн хэмжээ болж чадна. Энэ хэмжээ ерөнхийдөө шүлгийн мөрийн дотор адил тоотой байдаг бол өргөлтөөс тогтож байна. Монгол шүлгийг шүлэг болгож байгаа ганц тулгуур нь тоник /өргөлтөд/ хэмжээ мөн”⁶ гэж авч үзжээ. Тэгвэл Д. Жамба “Монгол бичгийн айзамт хэл нь /тогтолцоо нь/ шүлгийн мөр бүрт орох өргөлтөт үеийн тоог тэнцүүлэн бүтээдэг нь тодорхой. Монгол хэлний үгийн өргөлт нь тогтмол нэгдүгээр үедээ байдаг учраас шүлгийн мөр бүрт биеэ даасан үг хичнээн байвал өргөлт үеийн тоо төчнөөн байх нь мэдээж хэрэг ээ! Тиймийн тул шүлгийн мөр бүрт орох өргөлтөт үеийн тоог тэнцүүлэн монгол шүлгийн айзамт хэлийг бүтээдэг нь шүлгийн мөр бүрт биеэ даасан үгийг тэнцүү оруулж байгаад монгол шүлгийн айзамт хэлийг бүтээдэг гэж үзэхэд болно”⁷ гэж үзжээ. Мөн Ч. Чимид “Монгол үгийн хамгийн тод үе нь өргөлтөт үе юм. Тэр нь үгийн бусад эгшиг зарим гийгүүлэгчийг зохицуулах бусад үеийн огцом эгшигийг “баллаж” байгаа юм. Ийм хүчирхэг үеийн тоог нийлүүлж шүлэг бичнэ гэдэг нь тоник /өргөлтөт/ шүлгийн зохион байгуулалтын үндэстэй нягт холбоотой юм. ... Монголын одоогийн шүлгийн гол тогтолцоо нь өргөлтөт үеийн тоог тэгшитгэн, урт хос эгшигийн тоог гүйцэтгэх чиглэлтэй тоник тогтолцоо /өргөлтөт шүлэг/ байна”⁸ хэмээн үзсэн байна. Эдгээр судлаачдын судалгаа шинжилгээний үр дүнг нэгтгэн үзвэл:

-Монгол шүлэг өргөлтөт шүлэг

-Монгол шүлгийн өргөлт үгийн тэргүүн үедээ байна

-Монгол шүлгийн өргөлт үгийн тэргүүн үедээ байдаг нь цаад мөн чанартаа мөр хоорондын үгийн тоо тэнцүү байдаг гэсэн утгын илэрхийлэл. Энэ нь нэг мөрийн өргөлтөт үгүүд нь өгүүлэх эрхтний тогтолцоонд захирагдан хэмнэл үүсгэдэг онцлогийг хадгалж байна.

-Монгол шүлэгт өргөлтөт шинж чухал ч холбоцод давхар захирагддаг. Тэр дундаа монгол шүлэг толгой холбоцод захирагддаг онцлогтой байна.

Хоёрдугаарт, Германы монголч эрдэмтэн Б. Лауфер, буриадын шүлэг судлаач Г. Туденов, манай эрдэмтэн Б. Ринчен, Д. Цэрэнсодном нар монгол шүлгийг судлаад монгол шүлэг бол үет шүлэг гэж үзжээ. Тодруулбал, буриадын үлгэрийн шүлгийг дагнан судласан эрдэмтэн Г. Туденов “Үлгэрийн шүлгийг судлан үзвэл түүний яруу найргийн урлаг нь толгой холболт, өгүүлбэрийн гишүүдийн ангилалт, үеийн тоог тэгштгэх ба эн зэрэгцүүлэх эдгээр хэмжээт шүлгийн дөрвөн аргаас бүрдэж байна. Шүлгийн айзамыг бүрдүүлэх энэхүү аргыг бид уг хамаарагдаж буй төрөл зүйлийн шинжээр нь үлгэрийн шүлгийн тогтолцоо гэж нэрлэж байна. Энд өгүүлсэн дөрвөн аргаас шүлэг судлалын өнөөдрийн баримталж буй нийтлэг ойлголттой харьцуулан үзвэл хэмжээт шүлгийн ганц арга нь мөрийн доторх үеийг харьцангуйгаар тэгштгэх явдал юм. Хэн бүхэнд мэдээжээр шүлэгт үеийг тэгшитгэх зарчим нь үеийн шүлгийн /силлабик/ тогтолцоог дээр суурилдаг байна”⁹

² Владимирцов Б. Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Л., 1929. стр-98

³ Хамгашалов А. М. Опыт исследования бурятского стихосложения. Улан-Удэ., 1940. стр-32-33

⁴ Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл. Уб., 1957 25 дугаар тал

⁵ Гаадамба М. Утга зохиолын онолын товч. Уб., 1957 143 дугаар тал

⁶ Жамбалсүрэн Н. Монгол шүлэг. Утга зохиол сонин 1956. №8

⁷ Жамба Д. Монгол шүлгийн хэлний тухай. Монгол түүх хэлбичиг сэтгүүл. Уб. 1958. №3. 76 дугаар тал

⁸ Чимид Ч. Монгол шүлгийн тогтолцоо. “Үгийн ид шид” түүвэр Уб. 1968. 97-98 дугаар тал

⁹ Туденов Г. Бурятской стихосложение. Улан-Удэ., 1958. стр 82-83

хэмээн үзсэн бол манай эрдэмтэн Д. Цэрэнсодном “Монгол шүлгийг үзэхэд бичгийн шүлэг, аман бичгийн шүлэг, ардын аман яруу найраг гэдэг гурван зүйл гарна. Эдгээр нь чухамхүү шүлгийн хэмнэл айзам тааруулах тэргүүтэн ерөнхий зарчмын хувьд адил байна. Шүлгийн мөрийн хэмжээг ямар нэг нэгжээр тодорхой хэмжээнд журамлан бичдэг учир үг чухал оролцоотой нь үнэн боловч үг, түүнийг бүтээх үе хоёрын харьцааг эрэгцүүлэн бодох ёстой. Олонхи шүлгийг үзэхэд үгийн тоо зөрүү, тэнцүү янз бүр байх авч үеийн тоог яв цав тохируулан бичих нь гол зуршил бололтой байна. Монгол шүлгийн системийн /тогтолцооны/ талаар гэвэл ялангуяа ардын аман зохиол, хуучин уран зохиолын хувьд мөр бүрийн үеийн тоог чандлан бичдэг силлабик /үеийн/ шүлгийн зарчимтай байна”¹⁰ гэх мэтээр авч үзсэн байна. Энэ хэсгийн судалгааны үр дүнг нэгтгэн авч үзвэл:

-Монгол шүлэгт холбоц чухал үүрэгтэй. Тэр дундаа монгол шүлэг толгой холбоцод шууд захирагддаг.

-Монгол шүлэгт мөр бүрийн үгийн тоо тэнцүү байхыг чухалчлах ч цаад мөн чанартаа үгээс илүү мөр бүрийн үеийн тоог тэнцүүлж, нэг цогцолбор үүсгэх нөгөө мөртэйгөө тэгш хэмнэлт эн зэрэгцүүлэл үүсгэдэг гол онцлогтойг өгүүлсэн байна.

Гуравдугаарт, Оросын монголч эрдэмтэн А. М. Позднеев, германы монголч эрдэмтэн Г. К. Габленц нар монгол шүлгийн тогтолцоо тийм гэж хэлэхэд төвөгтэй, олон янзын нэгдмэл онцлогтой болохыг өгүүлээд яг ямар тогтолцоотой шүлэг болохыг нь өгүүлсэнгүй.

Дөрөвдүгээрт, Оросын монголч эрдэмтэн Л. К. Герасимович 1975 онд хэвлүүлсэн “Монгол шүлгийн тогтолцоо” бүтээлдээ монгол шүлгийг туршилт авиа зүйн аргаар судлаад “монгол шүлэг бол жигд цагтайгаар үл барам, үеийн тоогоор ч гэсэн ойролцоо ижилхэн байх нь ээ гэдэг дүгнэлт гаргахад хүргэв”¹¹ гэж бүр монгол шүлгийг өмнө судласан бүх эрдэмтдийн саналыг няцааж цоо шинээр “монгол шүлэг зохиол бол уугуул байгуулалынхаа цаг тооны шүлэг /квантитативный/ мөн”¹² хэмээн үзжээ.

Тавдугаарт, Өвөрмонголын эрдэмтэн Бүрэнбэх, Хишигтогтох, Сайшаалт, Сүюүгэ зэрэг судлаачид монгол шүлэг судлалаар их бага ямар нэг хэмжээгээр ажилласан ч монгол шүлгийн ерөнхий гол тогтолцоо, онцлогийн тухай цогцоор нь төдий л авч үзэлгүй түүхэн хөгжил хувьслын үүднээс хэсэг тасгаар нь олон янзаар судалсаар иржээ. Магадгүй тэдний судлал шинжлэлийн арга барил өөр байдагтай холбоотой биз. Гэхдээ л монгол шүлэг судлалд Өвөрмонголын судлаачдын бүтээлийг онцлон авч үзэх хэрэгтэй байгааг тэмдэглэе.

Монгол шүлгийн онцлогийг судалсан судлаачдын судалгаа дээрх хэдэн хэсэгт багцлагдах ч харьцангуй өөр өөр дүгнэлтэд хүрчээ. Ийнхүү монгол шүлгийн тогтолцооны асуудал өдгөө хүртэл нэг мөр шийдэгдээгүй ирсний учир нь дээрх судлаачид судалгаандаа хам хум, хайнга хандсан юмуу эсвэл элдэв олон янзын харийн онолын загварт монгол шүлгийг тавьсанд биш гагцхүү монгол шүлгийн өөрийнх нь өвөрмөц онцлогийн дотоод зүй тогтол руу зөв зам мөрөөр ороогүйтэй холбоотой бололтой. Шүлэг байгалиас хүний мэдрэхүйд өгөгдсөн айзам хэмнэл, өнгөний дагуу үгийн шүтэлцээ үүсгэж, тэдгээр үгс дотооддоо нарийн зохион байгуулалтанд орж, шүлгийн мөр улмаар бадаг үүсгэдэг онцлог нь бусад төрлийн зохиолоос ялгарах гол ялгаа нь болохыг онцлон судлах ёстой байжээ.

Хоёр. Монгол шүлгийг судлан шинжилсэн судлаачид судлан шинжилсэн асуудал бүрдээ тодорхой үнэлэлт дүгнэлтэд хүрсэн ч тэднийг цогцоор нь нэгтгэн дүгнээд үзвэл санал нийлсэн зүйл харьцангуй бага гэж хэлж болохоор байна. Энэ нь монгол шүлэг судлалд олон асуудлыг дахин нарийвчлан судлан шинжлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байгаа хэрэг. Монгол шүлэг судалсан судлаачдын судалгаанд хүлээн зөвшөөрөгдсөн нь харьцангуй цөөн ч доорх хоёр чухал асуудал нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн байна.

-Монгол шүлэг толгой холбоцод захирагддаг

-Монгол шүлэг тэргүүн үедээ өргөлттэй. Тэр өргөлт нь толгой холбоцтойгоо уялддаг. /Тэргүүн үедээ өргөлттэй төдийгүй, урт хос эгшиг өргөлттэй, сонсголт шуугиант гийгүүлэгчийн өмнөх юмуу хойтох эгшиг өргөлттэй/

Монгол шүлэг судлалаар ажилласан судлаачдын судалгаа шинжилгээний үр дүн яагаад ийм дүгнэлтэд хүрснийг ажиглаад доорх хэдэн зүйлийг өгүүлэх байна.

1. Монголчуудын аж амьдралын хэвшил, иргэншил, соёл сэтгэлгээний гүн утга агуулгатай судалгаа шинжилгээгээ хослуулалгүй хэтэрхий ганцаардуулан тусгаарлаж авч үзсэн
2. Монгол хүний аливаа зүйлийг ойлгох онцлог, түүнийгээ илэрхийлэн дүрслэх зүй тогтлыг сайн харгалзаж үзээгүй
3. Монгол шүлгийн онцлогийг уугуул монгол бичгийн хэлний зүй тогтлын үүднээс авч судлаагүй
4. Монгол шүлгийн төлөөлөл болохуйц үе үеийн шүлэгт цогц судалгаа хийлгүй хэсэг тасгаар хандсан байна.

Гурав, Монгол шүлэг судлалын түүхэн хөгжил хувьсал, гарсан үр дүнд тулгуурлаж цаашид монгол шүлэг судлалд доорх хэдэн зүйлийг нэн тэргүүнээ шийдвэрлэх нь тулгамдсан асуудал болжээ. Үүнд,

1. Шүлэг, яруу найраг, холбоо, хоршоо гэх зэрэг үгсийн гарал, түүхэн хөгжил хувьсал. Эдгээр үгс

¹⁰ Цэрэнсодном Д. Монгол шүлгийн тухай. Цог 1964 №4. 94-103 дугаар тал

¹¹ Герасимович Л. К. Монгольской стихосложение. М., 1975. стр-124

¹² Герасимович Л. К. Монгольской стихосложение. М., 1975. стр-125

Г.Галбаяр

хэдий үеэс хэрэглэгдэж, шүлэглэсэн зохиолыг нэрлэх болсон. Орчин үед тус бүрийнх нь нэршил, үүрэг, цаад агуулагдах утгыг тодорхой болгох.

2. Монгол шүлгийн холбоц, үе, өргөлт, айзам хэмнэлийн асуудлыг орчин үеийн техник технологийн дэвшлийг ашиглан шинээр судлан шинжлэх.

3. Монгол шүлгийг монгол хэл, нүүдлийн иргэншил, монгол хүний сэтгэлгээний мөн чанарын үүднээс цогцоор нь судлан шинжлэх.

4. Монгол шүлгийн гадаад хэлбэрийн ерөнхий тогтолцоо-зүй тогтлыг шүлгийн дотоод дүрслэгдэхүүнүүдтэй уялдуулан холбож судлах.

5. Дэлхийн уран зохиол дахь шүлэг судлалын хөгжилд гарч буй дэвшилттэй зүйлүүдийг харгалзан үзэж суурь шинжлэх ухаануудын нэгдэл бэлчир дээр тэдгээр ухаануудын судалгааны арга барилуудын үүднээс судлан шинжлэх.

6. Монгол шүлгийн дүрслэлийн ур маягуудыг цаад мөн чанар, дотоод учир шалтгааных нь үүднээс тогтолцоотой судлах.

Шүлэг үндэстний сэтгэхүй, хэл, соёлын цөм хэв загварын илэрхийлэл болдог учир түүнийг нарийвчлан судлах нь зайлшгүй чухал юм. Монгол шүлэгт хүн төрөлхтний шүлэг найрагт байх түгээмэл шинжүүд байх ч ямар нэг харь орны шүлэг найргаас зээлдэн авсан нь цөөн, зөвхөн өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүтэц тогтолцоотой болох нь тодорхой ажээ. Энэ л шинжнээс монгол шүлгийг цаашид судлан шинжлүүштэй юм.

Resume

Since poets are seen as expression of their national soul and living scenes, it is understood that poems keep a nation's basic mind styles. It is natural for any nation to determine their own history in the past and their future progress and development paths, having accurately studied their verse in many aspects both from outside and inside, within motivated scopes. Therefore, humankind highly respect and honor verse and comprehend it as their mirror to the past and diviner towards future.

Verse must be studied well so that we could study features of verse which method and regularities it is created, besides understanding past of living, future essence, and correlations kept in poems. Because it is related to that verse represented the basic mindset styles of the nation. It keeps all aspects of national language features.

Though history of Mongolian verse study had been started since the ancient times, however proper science based studies had been started from 19th century, and by 20th century many issues had been solved. Throughout the historical long terms Mongolian verse had gained quite systematized structure and due to evolution and development through many external and internal causes it has brought many issues for detailed study.

We have following goals for the purpose of this speech, which are, the first of all, to make integrated analysis on all studies on Mongolian verse made so far; the second, to determine main issues that were solved through the Mongolian verse study, and the third, to define issues that need to be studied within the framework of Mongolian verse study.

One. Mongolian verse study have taken its start from ancient years, and today it has been a systematized science branch. We have found that researchers from each generation have not only considered basic theory concepts of Mongolian verse, but also, studied it in connection with verse from other countries which had relationships in mind arts since ever.

Two. As a result of integrated analysis on researchers' studies in the past, we have found that though each researcher had reached conclusions at the end of his/her study, but the conclusions rarely meet each others vision. This means there are still need of re-study on many issues in the Mongolian verse study. However, as we observed, many researchers agree on fact that «Main feature in Mongolian poems is alliterativeness».

Three. Due to the finding that «Main feature in Mongolian poems is alliterativeness» or a concept that alliterativeness masters all other things in Mongolian verse, we consider that the following kinds of studies must be done:

- Some issues connected to rhymes, accents and metrics in Mongolian poems need to be re-studied with the use of advanced modern techniques and technologies;

- We face requirements to study Mongolian verse in complexity based on Mongolian language, traditional nomadic civilization and Mongolians mindset essence. Former researchers had studied Mongolian verse in non-complexity and we consider that many issues in doubt are connected to this.

- External basic structure-regularities of Mongolian verse must be studied in connection with its internally described objects.

Ном зүй

1. Аристотель Туурвил зүй. Орчуулсан М. Гаадамба. Уб., 1969
2. Байгалсайхан С. Уран зохиол шинжлэлийн удиртгал. Уб., 1995
3. Билигсайхан Ч. Ухаарахуй (Шинэ үеийн уран зохиолын онол) Уб., 2003
4. Буяннэмэх С. Утга зохиолын үүд. (Гар бичмэл эх) 1935
5. Владимирцов Б. Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Л., 1929
6. Гаадамба М. Утга зохиолын онолын товч. Уб., 1957
7. Гаадамба Ш. Утга зохиолын онолын үндэс. Уб., 1989
8. Галбаатар Д. Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл. Нэвтэрхий толь. Уб., 2012
9. Галбаяр Г. Уран зохиол шинжлэлийн лекц. Уб., 2002
10. Герасимович Л. К. Монгольское стихосложение. Л., 1975
11. Гуляев Н. А. Теория литературы. М., 1985
12. Гүлранса, Данзанванжил, Хишигбат Түүвэр. Хөх хот., 1959
13. Дамдинсүрэн Ц. Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай өгүүлэл. “Шинэ толь” сэтгүүл. Уб., 1938. №2 (14)
14. Дамдинсүрэн Ц. Олег цэцэний орчуулгын тайлбар. Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл. Уб., 1957
15. Дулам С., Хасбаатар Ц. Утга зохиолын үүд. Уб., 1980
16. Жамба Д. Монгол шүлгийн хэлний тухай өгүүлэл. Монгол түүх хэл бичиг сэтгүүл. Уб., 1958. №3
17. Жамбалсүрэн Н. Монгол шүлэг. Утга зохиол сонин 1956. №8
18. Жирмунский В. Теория стиха. Л., 1975
19. Инжаннаши В. Хөх судар. Тэргүүн дэвтэр. Хөх хот., 1959
20. Квятковский А. Поэтический словарь. М., 1983
21. Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл. Уб., 1957
22. Нацагдорж Дашдоржийн Бүрэн зохиол. Уб., 1996
23. Основы литературоведения (под редакцией В. П. Мещерякова) М., 2000
24. Отгонсүрэн Д. Д. Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог. Уб., 1984
25. Позднеев А. М. Образцы народной литературы монгольских племен. Вып 1. Спб., 1880
26. Поуха П. “Монголын нууц товчоо”-ны зарим нэгэн шинэ судалгаа. Монгол судлал. Уб., 1968
27. Ransom J. *Poems and essays*. N.Y., 1955
28. Ринчен Б. Монгол шүлгийн учир. “Хэл зохиол” цуврал бичиг. Уб., 1969
29. Руднеев А. Образцы монгольской народной словесности. СПб., 1880
30. Содном Б. Д. Нацагдоржийн уран зохиолын тухай. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. IV дэвтэр. Уб., 1962
31. Содном Балданы Монгол шүлгийн арга маяг. Зохиол судлал. Уб., 2008-2009
32. Туденов Г. Бурятской стихосложение. Улан Удэ., 1958
33. Түдэв Лодонгийн Шүлэглэсэн туульс. Бүтээлийн чуулган VI. Уб., 2002
34. *Uran üges-ün ёйүлүян. Qubisqal-un uran jokiyalçi nar-un бүligüm-eёе keblegүlbei. Mongyol keblel-ün qogiyан-a Uлауан бауatur qotan-a.*, 1929
35. Хамгашалов А. М. Опыт исследования бурятского стихосложения. Улан-Удэ., 1940
36. Хүрэлбаатар Л. Сонгодог уламжлал, монгол яруу найраг. Уб., 1989
37. Цэдэв Д. Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл. Уб., 1974
38. Цэнд Д. Монгол шүлгийн тогтолцооны асуудалд. “Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд” Уб., 1979
39. Цэрэнсодном Д. Монгол шүлгийн тухай. Цог 1964 №4.
40. Цэрэнсодном Д. Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал. Уб., 1977
41. Чимид Ч. Монгол шүлгийн тогтолцоо. “Үгийн ид шид” эмхэтгэл. Уб., 1968
42. Энхбаяр С. Утга зохиолын онол-туурвил зүй. Уб., 2000